



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/437

Хэрлэн сум

Сургалтад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 3 дугаар сарын 31 ний “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам батлах тухай” №24 тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 7 дугаар сарын 03-ны хорьдугаар хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Хэрлэн сумын лаборатори нэгдүгээр сургуулийн орос хэлний багш Д.Нансалмаа, Т.Ганжаргал нарийг Оросын холбооны улсын Уралын холбооны их сургуульд зохион байгуулах сургалтад хамрагдан туршлага судлахад зориулж 2,500,000 (хоёр сая таван зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудад дэмжлэг үзүүлнэ” зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ